

Сонгон шалгаруулалтын урилга

“Монголын төмөр зам” ТӨХК нь дараах зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулж хамтран ажиллана.

Саналыг 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 17 цагаас өмнө “Монголын төмөр зам” ТӨХК-ийн байранд /Улаанбаатар хот 14230, СБД, 1-р хороо, 13-р хороолол, Нарны зам-62, Юнион Бюлдинг А блок, 7 давхар/

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын Их Хурлаас 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого: “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд “Монголын төмөр зам” ТӨХК-ийн хэрэгжүүлсэн Тавантолгой-Зүүнбаян, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хэрэгжүүлж буй Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслүүд дуусч, бүрэн ашиглалтанд орж байгаатай холбогдуулан нэгдсэн удирдлага зохион байгуулалт, нэгдсэн төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах шаардлага үүссэн. Үүнтэй холбогдуулан галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалт, ачаа тээвэрлэлтийн ажиллагааны цогц бодлого тодорхой биш, хөдлөх бүрэлдэхүүний хомсдол, тээвэр зохион байгуулалт, хүний нөөцийн бодлогыг шинэчлэх, шинээр ашиглалтанд орсон төмөр замын урсгал засварын ажлын зохион байгуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хүчин чадлыг нэмэгдүүлэх, боломжит хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсад угсрах, модернизац хийх боломжуудыг судлах, төмөр замуудын

компанийн оновчтой бүтцийг боловсруулах, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд мөрдөх тарифын нэгдсэн бодлогын баримт бичиг боловсруулахаар төлөвлөж байна.

Зорилго:

Зөвлөх үйлчилгээний зорилго нь төмөр замын компаниудын менежментийг үр ашигтай зохион байгуулахад загварчлал гаргах, “Монголын төмөр зам” ТӨХК, “Тавантолгой төмөрзам” ХХК-уудын засаглалыг сайжруулж үйл ажиллагааг уялдуулах, бүтцийн оновчтой хувилбар боловсруулах замаар тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах цогц, шаталсан төлөвлөгөө, бодлогын баримт бичиг боловсруулахад оршино.

Захиалагч:

“Монголын төмөр зам” ТӨХК

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:

“Монголын төмөр зам” ТӨХК, “Тавантолгой төмөрзам” ХХК

Төслийн дугаар:

MT32023 TOR

Үйл ажиллагааны дугаар:

MTZ 23 Бизнес хөгжүүлэх зөвлөх үйлчилгээ

Гүйцэтгэх хугацаа:

1 /нэг/ сар

Ажлын хамрах хүрээ:

1. Төмөр замын салбарын олон улсын гэрээ, хэлэлцээрийг судлаж, түүнд хэрхэн оролцох, олон улсын төмөр замын байгууллагуудад эзлэх байр суурийг тодорхойлох;
2. MTЗ ТӨХК, ТТЗ ХХК-ууд нь үйл ажиллагааны хувьд төмөр замын ашиглалтын түвшинд шилжсэнтэй холбогдуулж, тус төмөр замуудын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журмуудын хүрээнд зам, вагон, зүтгүүр, дохиолол, холбоо, тээвэр зохион байгуулалтын бүтэц, орон тоог дэлхийн шилдэг үйл ажиллагаатай төмөр замуудын жишгээр боловсруулах;
3. Өнөөгийн бодит байдалд суурилсан ачаа, тээврийн төлөвлөлт, оновчтой хувилбар, үечлэн нэмэгдүүлэх хөдлөх бүрэлдэхүүний тоо хэмжээтэй уялдуулсан компанийн үйл ажиллагааны ойрын болон хэтийн төлөвлөлтийг боловсруулах;
4. Зүтгүүр болон вагоныг гадаадын зах зээлээс авах боломжийн судалгаа, харьцуулалт болон боломжит хөдлөх бүрэлдэхүүнийг Монголд үйлдвэрлэх/угсрах бололцоо, эдийн засгийн үр ашгийн тооцоог гаргах;

5. Тээврийн хэмжээтэй уялдуулсан боловсон хүчний бодлого боловсруулах;
6. Гадаадын зээл, тусламж авах боломжуудыг судлах;
7. Ачих буулгах технологийн ерөнхий концепци боловсруулах;
8. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудын тээх нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлэх боломжийг судлан санал боловсруулах;
9. Зүүнбаян-Сайшанд-Замын-Үүд чиглэлд төмөр замуудын тээх нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлэх боломжийг судлан санал боловсруулах;
10. Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын тээврийн үнэ, тарифын судалгаа хийж, нэгдсэн бодлого боловсруулж батлуулах.

Зөвлөхөд тавигдах шаардлага:

Зөвлөх нь дараах шалгууруудыг хангахуйц хуулийн этгээд байна.

- Төмөр замын чадварлаг мэргэжилтнүүд бүхий тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байх:

- Сүүлийн 5 жилийн хугацаанд төмөр замын зураг төсөл, төсөв, техник эдийн засгийн үндэслэл боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулсан байх;
- Гэрээний хугацаанд ажил үүргээ гүйцэтгэх боломжтой байх;
- Англи, Орос, Хятад хэлний мэргэжлийн түвшний мэдлэгтэй байх;
- Багаар ажиллах чадвартай;
- Статистикийн салбарт ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.